

Оршил


Тэмээн сүрэг нь манай орны цөл, цөлөрхөг бүсийн байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлд сайтар зохицсон, ноос, мах, сүүний сайн чанартай арвин их ашиг шим өгдөг. Тэмээг монголчууд эрт дээр үеэс ачлага уналганд ашиглаж нүүх суух, алсын аян жин тээх, ачих, тэргэнд хөллөх, унаж эдлэх зэргээр нүүдлийн ахуй амьдралд зохицуулан ашиглаж ирсэн уламжлалтай. Улс орны эдийн засаг бууралттай, байгаль орчны бохирдол ихтэй, хүн амын зохисгүй хэрэглээ өндөр болсон гэх мэт амьдралын хэв маягт сөрөг нөлөөлөл ихээр бий болсоор байгаа өнөө үед тэмээн сүргийн ашиг шим, хэрэглээг таниулах, нэмэгдүүлэх, тэмээн соёлыг нэвтрүүлэх, сүргийг өсгөх зэрэг ажлуудыг зохион байгуулах, тэмээн сүргийг анхааралдаа авах шаардлага үүсэн гарч байна.

Өвөрхангай аймгийн хувьд хангай, говь, тал хээрийн бүс зэрэгцэн оршсон газар зүйн маш өвөрмөц бөгөөд таатай нөхцөлтэй аймаг юм. Энэ байдалдаа тулгуурлан малчдын амьжиргааг дээшлүүлэх шинэ нөөц боломжийг илрүүлэх, аж ахуй эрхлэх менежментийн олон төрлийн сувгыг бий болгох, сүлжээг боловсронгуй болгох хэрэгцээ бий болж байна.

Судалгааны хэсэг

Манай Өвөрхангай аймаг 1930-аад оны үед 77.6 мянган тэмээтэй байж, 1939 онд хамгийн өндөр буюу тэмээн сүргийн тоо 108.6 мянгад хүрч байжээ. 1950-иад оноос тасралтгүй буурсаар 2014 онд 22.0 мянган толгой тэмээ тоологдсон байна. 2006 онд хамгийн бага буюу 13.0 мянган толгойд хүрч үүнээс хойш өнөөг хүртэл өсөлттэй байсаар байгаа нь бага боловч эерэг үзүүлэлт юм. Монгол улсын тэмээн сүргийн тоо 2014 оны байдлаар 349.3 мянга байгаагийн 6.3 хувь нь манай аймагт байна. Хангай говийн бүс хосолсон манай аймгийн хувьд тэмээн сүргийн тоогоор улсдаа Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Дундговь зэрэг аймгуудийн дараа зургаадугаарт орж байна. Өмнөговь аймаг 112.7 мянган тэмээгээр улсдаа тэргүүлж, Баянхонгор аймаг 41.7 мянга, Дорноговь аймаг 34.8 мянга, Говь-Алтай аймаг 32.8 мянга, Дундговь аймаг 28.0 мянган тэмээгээр тус тус удаалж байна.

График 1.



Байгаль цаг уурын болон зах зээлийн орчны таатай бус өөрчлөлтийн улмаас малчдын амьжиргааны түвшин тогтвортой бус байдлаар байнга өөрчлөгдөж байдаг. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үр ашигтай суваг бүрдээгүй нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд бодит саад бэрхшээл учруулдаг.

Малын тоо өсөөд байхад малчдын амьжиргаа сайжрахгүй байна. Улсын эдийн засагт чухал байр эзэлдэг мал аж ахуйн салбарын бүтэц зохион байгуулалт, хөгжлийн чиг хандлага төдийлөн тогтвортой бус байна. Үүнээс үүдээд дараах зарим сөрөг үзэгдлүүд нь бий болох хандлага бий болох талтай.

- малчин өрхийн аж ахуй үндсэндээ ганцхан салбар буюу мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг, тэр нь бүтээмж багатай;
- малчин өрхийн аж ахуй нь хэмжээний хувьд хэт жижиг, зах зээлд өрсөлдөх чадвар сул, дийлэнх нь амиа аргацаасан шинжтэй;
- хоорондоо хамтран ажиллах аж ахуй, хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр тодорхой бус;
- бүтээгдэхүүн, түүхий эдээ зах зээлд оновчтой, үр ашигтай борлуулж чадахгүйгээс завсрын наймаачид илүү хождог;

- орлогын гол эх үүсвэр нь үндсэндээ малын тооноос шалтгаалдаг, малын тоо нь байгаль, цаг уурын сөрөг нөлөөнөөс ихээхэн хамаардаг тогтвортой амьжиргааны эх үүсвэр болж чадах эсэх нь эрсдэлтэй;
- байгаль, цаг уурын нөлөөлөл, зуднаас шалтгаалж мал ихээр хорогдож, малгүй, орлогын эх үүсвэргүй болж, малчдын амьжиргааны төвшин буурах давтамж ойр ойрхон тохиолддог болсон;

гэх мэт эдгээрийг их, бага ямар нэг хэмжээгээр шийдэж болох нэг арга нь малчдын амьжиргааг дээшлүүлэх, дэмжих нэг эх үүсвэр суваг нь тэмээн сүрэн байж болохоор юм.

Ерөнхийдөө тэмээн сүргийн тооны эрчимтэй бууралт нь 1960-1980-аад онууд байсан ба 1990-2006 онуудад аажим буурсаар 2007 оноос өсөх хандлагадаа орсон байна.

Хүснэгт 1.

Тэмээн сүргийн зарим үзүүлэлтүүд, сүүлийн 6 жилд

Үзүүлэлтүүд	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Нийт сүрэгт тэмээн сүргийн эзлэх хувь	0.4	0.5	0.7	0.7	0.6	0.6	0.5
Том малын зүй бусын хорогдол, мян.толгой	-	0.076	0.8	0.02	0.02	0.02	0.03
Ингэний тоо, мян.толгой	4.4	4.7	4.9	5.6	6.4	7.6	7.8
Хээл хаясан ингэ, мян.толгой	-	0.01	0.01	0.02	0.02	0.003	0.005
Сувайрсан ингэ, мян.толгой	0.1	0.08	0.2	0.08	0.2	0.06	0.13
Бойжсон ботгоны тоо, мян.толгой	2.1	2.3	1.7	2.9	3.2	2.9	3.6
Буурны тоо, мян.толгой	0.2	0.22	0.21	0.22	0.23	0.24	0.24
Зах зээлд худалдан борлуулсан, мян.толгой	0.4	0.5	0.9	0.7	0.8	0.8	1.0
Аж ахуйн дотоодод хэрэглэсэн, мян.толгой	0.7	0.5	0.8	0.5	0.5	0.4	0.4


Нийт сүрэгт тэмээн сүргийн тооны эзлэх хувь нь 2008 онд 0.4 хувь, 2009 онд 0.5 хувь, 2010 онд 0.7 хувь, 2011 онд 0.7 хувь, 2012 онд 0.6 хувь, 2013 онд 0.6 хувь, 2014 онд 0.5 хувь байгаа нь тэмээн сүрэг өсч байгаа хэдий ч нийт сүрэгт эзлэх хувь нь өсөлтгүй байгааг харуулж байна.

Сүргийн бүтцийн хувьд 2013 оны байдлаар 40 хувийг төл, өсвөр насны мал эзэлж, энэ нь 2014 онд 43.9 хувь байгаа нь сүргийн тоо өсөх хандлагадаа орсонг харуулж байна.

Өвөрхангай аймгийн тэмээн сүргийн өнөөгийн байдал

Ингэний тоо болон байжсон ботгоны тоо байнга өсч байгаа нь тэмээн сүрэг өсөх чигтэй байгааг харуулах үзүүлэлт юм.

График 2.



Дээрх үзүүлэлтүүдийн хамаарлыг олон хүчин зүйлийн шинжилгээ хийж үзэхэд:

Хүснэгт 2.

SUMMARY OUTPUT


Correlation Statistics

	Нийт сүргийн тоо	Том малын зүй бусын хорогдол	Ингэний тоо	Хээл хаясан ингэ	Сувайрсан ингэ	Бойжсон ботгоны тоо	Буурны тоо	Зах зээлд худалдан борлуулсан	Аж ахуйн дотоод хэрэглэсэн
Нийт сүргийн тоо	1								
Том малын зүй бусын хорогдол	-0.641	1							
Ингэний тоо	0.805	-0.488	1						
Хээл хаясан ингэ	-0.198	-0.216	-0.262	1					
Сувайрсан ингэ	-0.142	0.592	-0.243	0.375	1				
Бойжсон ботгоны тоо	0.713	-0.872	0.694	0.392	-0.251	1			
Буурны тоо	0.93	-0.712	0.926	-0.275	-0.402	0.767	1		
Зах зээлд худалдан борлуулсан	0.011	0.535	0.377	-0.049	0.595	-0.082	0.029	1	
Аж ахуйн дотоод хэрэглэсэн	-0.731	0.963	-0.635	0.04	0.689	-0.824	-0.839	0.457	1

Тэмээн сүргийн тоог үндсэн үзүүлэлт болгон авч энэ үзүүлэлтийг 1-р өөрчлөгдөхөд бусад үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж буйг үзлээ. Хүснэгт 2-оос харахад нийт сүргийн

тооны өөрчлөлтөд ингэний тоо болон бойжсон ботгоны тоо эерэг нөлөөтэй, том малын хорогдол сөрөг нөлөөтэй нь мэдээжийн боловч шинжилгээгээр батлагдлаа. Ингэний тооны өөрчлөлтөд буурны тоо болон ботгоны тооны өөрчлөлт хамгийн их эерэг нөлөөтэй, бойжсон ботгоны тооны өөрчлөлтөд мөн буурны тоо хамгийн их эерэг нөлөөтэй, аж ахуйн дотоод хэрэглээ харин хамгийн их сөрөг нөлөөтэй гэх мэт нөлөөллүүд харагдаж байна.

График 3.



Нийт тэмээн сүрэгт хорогдлын эзлэх хувийг 1945 оноос хойш авч үзвэл хамгийн ихдээ 1945 онд 22.6 хувь, хамгийн багадаа сүүлийн жилүүд буюу 2011-2014 онуудад 0.1 хувийг эзэлж байна. 1945 оны хувьд 1944-1945 оны мичин жилийн зуд болж байсан гэдгээрээ онцлог байсан боловч уу, сүүлийн жилүүдэд бол тэмээн сүргийн хорогдол бага хувийг эзэлж байгаа нь эерэг үзүүлэлт юм.

1945 оноос хойших тэмээн сүргийн тооны өсөлт, бууралтад хорогдлын нөлөөлөл ямар байгааг регрессийн бодолт хийж харахад:

SUMMARY
OUTPUT

<i>Regression Statistics</i>	
Multiple R	0.80053
R Square	0.64085
Adjusted R Square	0.62614
Standard Error	1.87809
Observations	69

ANOVA					<i>Significance F</i>
	<i>df</i>	<i>SS</i>	<i>MS</i>	<i>F</i>	<i>F</i>
Regression	1	427.98244	427.98244	121.33635	0.00000
Residual	68	239.85233	3.52724		
Total	69	667.83476			

	<i>Coefficients</i>	<i>Standard Error</i>	<i>t Stat</i>	<i>P-value</i>	<i>Lower 95%</i>	<i>Upper 95%</i>	<i>Lower 95.0%</i>	<i>Upper 95.0%</i>
Тэмээн сүргийн хорогдол	0.05323	0.00483	11.01528	0.00000	0.04358	0.06287	0.04358	0.06287

Дээрх үзүүлэлтүүд нийцэлтэй бус буюу сөрөг үзүүлэлтүүд бөгөөд стандарт алдаа нь 1.8 байна. Тэмээн сүргийн тоо 1-ээр өсөхөд хорогдол 0.05-аар нэмэгдэнэ гэсэн утга харагдаж байна. Өөрөөр хэлбэл шинжилгээгээр тэмээн сүргийн тооны өсөлтийг хорогдол 0.05 –аар дагана гэсэн үр дүн гарлаа.


Өвөрхангай аймгийн говийн 3 сумын иргэдээс тэмээн сүргийн өсөлт, бууралтын өнөөгийн байдлын талаар товч санал асууж үзлээ. Цөөн хүнээс асуусан хэдий ч сонирхолтой байх болов уу гээд санал асуулгын дүнг нэгтгэж харууллаа.

Судалгаанд говийн 3 сумын 120 иргэн хамрагдсан ба нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 29 нь албан хаагч, 61 малчид буюу иргэд байлаа.

- Тэмээн сүргийг өсгөхөд төрийн бодлого зайлшгүй хэрэгтэй юу гэсэн асуултад нийт судалгаанд хамрагдсан хүний 96.6 хувь нь зайлшгүй хэрэгтэй гэж хариулсан байна.

- Тэмээн сүргийн тооны бууралтад нөлөөлж буй гол хүчин зүйлийн талаар асуухад Нийт судалгаанд хамрагдсан хүний 35.0 хувь нь тэмээний түүхий эдийн ашиглалт муу, үнэ хямд, 34.0 хувь нь уналга эдэлгээний хэрэглээ буурсан, 21 хувь нь өсөлт удаан /жил өнжиж төл өгдөг/, 6 хувь нь бэлчээрийн байдал, 4 хувь нь цаг агаарын байдлаас үүдэлтэй гэж хариулсан байна.


График 4.



-Тэмээг уналга эдэлгээнд ашиглах хэрэгцээг бий болгох боломж бий юу? Нэрлэнэ үү? гэсэн асуултад нийт хариулагчийн 51.3 хувь нь аялал жуулчлалд ашиглах, хэрэглээ болгох боломжийг нэрлэсэн бол 31.2 хувь нь бүх нийтэд ялангуяа залуу үед, нутгийн ард иргэдэд тэмээн соёлыг таниулах, сурталчилах ажлыг зохион байгуулах гэж хариулсан байна. Боломж бага, ер нь бараг байхгүй гэсэн хариултыг 13.2 хувь нь өгсөн бол үлдсэн 4.3 хувь нь өвлийн цагт мал маллагааны гол уналга болгож хэвшүүлэх, хятад мотоциклийн хэрэглээг багасгах /зарим нь бүр хятад мотоциклийг монголд оруулж ирэхийг хаах тухай/ гэх мэтээр нэрлэсэн байна.

График 5.

Өвөрхангай аймгийн тэмээн сүргийн өнөөгийн байдал



- Тэмээн сүргийг өсгөх тал дээр таны санал гэсэн асуултад судалгаанд хариулагчид нэлээд төрлийн санал бичсэн байна. Үүнд:

- тэмээний ашиг шимийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх
- бүтээгдэхүүний чанарыг таниулах, жишээлбэл ноос нь хямд боловч ноолууртай дүйцэхүйц хэмжээний чанартай талаар, мөн сүү саалийн бүтээгдэхүүн нь хүний биед маш чухал сайн нөлөөтэй
- Тэмээ алсын барааг өдөр шөнө ялгалгүй хардаг. Үнэр сайн мэдэрдэг. Ус, худаг, айл бууцыг 30-аад км-ийн цаанаас мэдэрдэг гэдэг. Иймээс ямар ч элсэн цөлд баримжаагаа алддаггүй орон зайн мэдрэмж сайтай тул хэрэглээг сурталчилах
- Тэмээний бас нэг сонин зохилдолгоо бол агаарын температур ихсэх үед хөлөрч усаа алдахгүйн тулд биеийн температураа нэмэгдүүлэн өнгөрөөж чаддаг явдал юм. Тэмээ бөхнийхөө өөхийг задлан ус болгож чадна. Өдөрт 80 л хүртэл ус уудаг. Үүнийг гүзээндээ олон хоног хадгалан аажим зарцуулж чаддаг. Тиймээс тэмээг идүүлэх ч үгүй, услах ч үгүй байлгахад 56-70 хоног, өвс өгч услахгүй байлгахад 78 хоног, зөвхөн ус өгч байгаа нөхцөлд 86-131 хоног тэсч чаддаг гэх мэтээр тэмээний ашиг тус, сайн талуудыг дурдаж тэмээн соёлыг нэвтрүүлэх хэрэгтэй талаар саналууд бичсэн байна.
- Тэмээ хорогдох хэд хэдэн шалтгаануудыг дурдсан байна. Үүнд: махны гарц сайтай учраас нядалгаанд их хэрэглэдэг. Мөн түүнчлэн ачаа тээвэрт хэрэглэх шаардлага хэрэгцээ багассан. Бага оврын трактор, Портер, Бонго гэх мэтийн бага оврын ачааны автомашин өргөн хэрэглэгдэх, тэмээ шилэрч хол идээшилж явдаг хариулга багатай зэргээс шалтгаалан тоо толгой буурч байна гэх мэт.

Цөөн хүнээс судалгаа авахад дээрх байдлаар судалгааны үр дүн гарлаа. Тэмээг уналга, эдэлгээнд хэрэглэх талаар "Тэмээний аж ахуйн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх арга зам" Ю.Адъяа судалгаагаар дараах сонирхолтой мэдээлэл гарсан байна.

“Тэмээг буйллаж, бурантгаар хөтлөх аргыг зөвхөн Монголчууд хэрэглэдэг. Буйлыг модоор зорж хийдэг ба энэ нь машинаар бол руль нь гэсэн үг бөгөөд тэмээг аль зүг рүү явахыг чиглүүлж өгдөг зүйл юм. Буйллахын тулд ногтолж таваглан даруулаад буйлаар нь юм уу, оонын эврээр хийсэн соёо, эсвэл хоёр талдаа иртэй гилбэр хэмээх тусгай төмрөөр хамрыг нь цоолж буйландаа товх хийж буруу талаас нь буйлаа хийж зөв талд нь мөн товх хийгээд бурантаг уядаг. Тэмээг 2-3 настайд нь унаж сургадаг бол 4-5 насанд нь ачилга, хөллөгөнд сургадаг. Ачлаганд сургахдаа хомнож, номхон тэмээний араас хөтөлж сургаад аажмаар хөнгөн ачаанд дасгана. Тэмээ нуруундаа 200-240 кг, тэргэнд хөллөсөн үед 400-500 кг ачаа тээж чаддаг. Аян жинд явахдаа тэмээний хамрыг гэмтээхгүйн тулд бурантгийг нь урд тэмээний татлаганд өвс шүүрч байхаар зайтай хавчуулж хэлхдэг учир тэмээн ачаа тасарч хоцрохоос сэргийлж сүүлчийн тэмээний хүзүүнд хонх зүүдэг. Аян жинд явах тэмээг 10-15 хоног сойно. Тэмээг уяж сойсноор бие нь хагсарч өлчиржин, ул таваг нь бөхөждөг онцлогтой. Номхон тэмээг ганц хүн ачих тохиолдолд 1 м орчим урт үзүүртээ ац буюу тээглүүртэй хоёр тийш нь сураар тэнцүү гоцоо гаргасан “Хүн мод” хэрэглэн ачна. Хоёр тийш гаргасан суран гогцоог тэмээний шатанд углаж татлагаа дээр нь тавиад хүн модоо налуу байрлуулж үзүүрийг газар хатган тэнгээ ачаад нөгөө талд нь гарч ачдаг арга юм. Эрдэмтдийн тогтоосноор жингийн тэмээ цагт 3.5-4.5 км, хоногт 30-40 км явдаг бөгөөд алсын аянд гурав хоног яваад нэг өдөр амардаг байна. Өмнөговь аймгаас Улаанбаатар хүртэл цагт 4 км,хоногт 37 км газрыг туулж 740 км газрыг 20 хоногт туулдгийг тогтоосон байна.”

Дүгнэлт, санал

Дэлхийн мал амьтны бүртгэлд хос бөхт тэмээ гэж тодотгогдон нэршсэн бидний мэдэх монгол тэмээ Монголын говь, цөлийн эрс тэс байгаль цаг уур, бэлчээрийн мал маллагаанд илүү зохицсон амьтан. Дэлхийд 23 сая тэмээ байдгийн 2.8 хувийг хос бөхт тэмээ эзэлж, түүний бараг 50 шахам хувь нь манай улсад байгаа гэсэн тоон мэдээ бий. Монгол улсын тэмээн сүргийн 6.3 хувь нь манай аймагт байдаг ба энэ нь цөөн тоо мэт харагдаж байгаа ч 5 хошуу малын дотор өвөрмөц онцлого бүхий тэмээн сүргийн хувьд чамлахааргүй тоо юм. 1939 онд манай аймгийн тэмээн сүрэг 100.0 давж байсан байна. Үүнээс хойш байнга буурсаар ирсэн ба 2007 оноос тэмээн сүрэн өсөлттэй байгаа хэдий ч

өсөлт удаан байна. Малын өсөх эс өсөхийг сүргийн бүтэц харуулдаг. Сүргийн бүтцийн хувьд эерэг үзүүлэлттэй байгаа хэдий ч бэлчээрийн талхлагдалт, цөлжилттэй холбоотойгоор хангалттай өсөх хэмжээнд хүрч чадахгүй байна. Тэмээчдийг хөдөлмөрөө хоршиж бүлэг, хоршоо байгуулах үйл ажиллагааг дэмжих төрийн бодлого, хөтөлбөр, төслөөс тодорхой зорилтуудыг хэрэгжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тэмээний ноос, сүү боловсруулах жижиг үйлдвэр, цех байгуулахыг төрийн болон орон нутгийн зүгээс тодорхой дэмжлэг хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нүдний өмнө өнгөрч байгааг бид харж байгаа. Тэмээн сүргийн гол нутгуудад цөлжилт хурдацтай явагдаж тэмээний үндсэн нутгийн байгаль, экологи өөрчлөгдөж байна. Тухайлбал тал хээр, говийн бүсэд шороон шуургатай, нутаг дэвсгэрийн тодорхой хувь нь цөлжилтөд ямар нэг хэмжээгээр өртсөн зэргээс болж тэмээний үндсэн хүнс болох бор, улаан бударгана, баглуур, шаваг, бут сөөглөг ургамлын зүйлийн бүрэлдэхүүн хомсдож, зарим газар нутгуудад бүр ургахаа ч больж байгаа тухай судлаачид судалсаар байна. Тэмээ өсгөсөн тохиолдолд урамшуулах, ялангуяа бойжуулсан ботго тормонд урамшуулал өгөх, говьд ажиллаж амьдарч байгаа хүмүүст бүсийн нэмэгдэл өгөх, бэлчээрийг усжуулах, томоохон уурхай ажилаж байгаа газруудад бэлчээрийг нөхөн сэргээх зэрэг нийгмийн чанартай асуудлыг хөндөж хөтөлбөр хэрэгжүүлэх арга зам хайх шаардлага урган гарч байгаа мэт.

Ашиг шим өндөртэй, өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий тэмээн сүргийг анхаарч үзэн, говийн бүсийн малчдын орлогыг нэмэгдүүлэх бас нэг эх үүсвэр нь тэмээн сүрэг байгааг сонирхох хэрэгцээ бий болж байна. Энэ асуудлыг шийдэх арга зам бол нарийн нягт судалгаан дээр тулгуурласан оновчтой цогц бодлого, түүнийг хэрэгжүүлэх шийдвэр гаргах төвшнийхний анхаарах бас нэгэн асуудал болж байна.